



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

“Глобал-Ассет ҮЦК” ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

“Глобал-Ассет ҮЦК” ХХК-аас үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах тухай хүсэлт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.1 дэх заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 11.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Глобал-Ассет ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Глобал-Ассет ҮЦК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, баримт хүлээлцэх ажлыг зохион байгуулж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төлөөлөл бүхий комисс томилон ажиллуулахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/, арилжаа болон санхүүгийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/ архивт хүлээн авахыг тус тус үүрэг болгосугай.

4. Харилцагчийн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн баримтыг “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 12.9.1-д заасны дагуу цэгцлэн архивын нэгж болгон арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын архивт 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх болон харилцагчтай холбоотой аливаа хүсэлт, өргөдөл, гомдолыг бүрэн барагдуулах, харилцагчдыг хууль, журмын дагуу бусад тусгай зөвшөөрөлтэй этгээдэд шилжүүлэхийг “Глобал-Ассет ҮЦК” ХХК /Шин Со Воо/-д үүрэг болгосугай.

000878

5. Тус компанийн харилцагчдыг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харъяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА  З.НАРАНТУЯА